



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 660

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч С.Өлзийхүүгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-

006021333

2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч С.Өлзийхүү Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч С.Өлзийхүүгийн мөрийн хөтөлбөр (.....*д*.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч С.Өлзийхүүд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ СОДНОМЫН ӨЛЗИЙХҮҮГИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 1.1 Малчдыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах, алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах бодлогыг дэмжинэ.
- 1.2 Эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, эргэлтийн эмийн сангийн нөөц, эрт илрүүлэгт багийн иргэдийг хамруулах ажлыг сурталчлах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, цанын спорт болон урлагийн авьяастай хүүхдүүдийн авьяасыг нээн илэрүүлэх, сурталчлан таниулах бодлогыг дэмжинэ.
- 1.4 Иргэд амьдрах орчин нөхцлөө сайжруулах, био ариун цэврийн байгууламж барих, нийтийн эзэмшлийн талбайд мод бут тарьж ургуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5 Өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийг зээлийн хөтөлбөрт хамруулах замаар өрхийн амжиргааны төвшинг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.6 Залуучуудад бизнес эрхлэхэд шаардлагатай орчин нөхцлийг бүрдүүлэх, бодлогыг дэмжинэ.
- 1.7 Жижиг дунд үйлдвэрлэл, гар урлал эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлсийг борлуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.8 Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 1.9 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.10 Төсвийн орлогын төлөвлөлтийн үндэслэлтэй хийж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан, өр авлагыг барагдуулах, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд иргэд хяналт тавих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.11 Сумын төсөв, түүний төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг олон нийтэд нээлттэй санал асуулгаар явуулах, гүйцэтгэлд иргэд хяналт тавих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.12 Аялал жуулчлалын бүсэд худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийн ариун цэврийн байгууламжийг байгальд ээлтэйгээр шинэчлэх, шинээр байгуулах бодлогыг дэмжинэ.
- 1.13 Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлогыг баримтлана.
- 1.14 Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.

1.15 Иргэдийг хүнсний ногоо, ногоон тэмжээл тариалах үйл ажиллагааг идэвхжүүлэх, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх, нөхцөлийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.16 Суманд нэн шаардлагатай багш, эмч болон бусад төрийн албан хаагчдыг тогтвор сууршилтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, залуу албан хаагчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

О.Х.М

/С.ӨЛЗИЙХҮҮ/ 99018621

